



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А132

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Алсын удирдлагатай хэт богино долгионы радио станцын дамжуулах байгууламжийн нөөц шугам түрээсийн үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	М.Эрдэнэсүх	Холбоо, навигаци, ажиглалтын албаны дарга
Нарийн бичгийн дарга:	Ч.Ганзориг	Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн
Гишүүд:	Ч.Бат-Оргил	Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холбооны хэсгийн өгөгдлийн холбооны тасгийн өгөгдлийн холбооны ахлах инженер
	Д.Цэцэгмаа	Иргэний нисэхийн залуучуудын холбооны гишүүн
	Л.Алтан-Од	"Од хөгжил" Төрийн бус байгууллагын тэргүүн

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (М.Эрдэнэсүх)-нд үүрэг болгосугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендер нээхэд Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Хуулийн хэлтэст хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ч.Ганзориг)-д даалгасугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

1721 01 1003